*Орон бүхний пролетари нар нэгдэгтүн!*

# Анх дугаар ТАВАН ЖИЛ

*Төв аймгийн намын хороо, А.Д.Х. Гүйцэтгэх захиргааны сонин.*

17 дэх жилдээ №72 (1377) | 1964 оны 9 дүгээр сарын 17 | ПҮРЭВ

## Зузаан тарга—зудын хуяг

Малаа дээд хэмжээгээр таргалуулах нэгэнт авсан тарга хүчийг хадгалаж тогтоох ажлыг аж ахуйн том кампанит ажил болгон зохиож байгаа нь мал сүргийг өсгөх, үүлдэр чанарыг сайжруулж ашиг шим нэмэгдүүлэхэд асар их ач тус үзүүлж байгаа билээ. Манай малчин олны дотроос төлөө сайн бойжуулж хээлтэгч бүх эх малыг бүрэн хээл авахуулж, сүү,ноос,үс арвин их авч байгаа хүмүүсийн амжилт нь чухамдаа малын тарга хүч хир зэрэг байснаас шууд шалтгаалдаг. Тарган мал тал бүрийн ашигтай гэдгийг малчин хүн бүр мэднэ.

1964 онд аймгийн намын хороо, гүйцэтгэх захиргаа малыг зохион байгуулалттай гурван үе хугацаагаар оторлож тарга хүч авахуулах ба хүч тогтоох тухай шийдвэр гаргасны дагуу манай сангийн аж ахуй, нэгдлүүдийн малчид сууръ хэсгээрээ оторнүүдэл зохиож байна.

Баян,Баянцагаан,Заамар сумын нэгдлүүд малаа таргалуулах оторлолтыг нарийн төлөвлөгөө хуваариар зохиож байгаагаас эдгээр сумдын малын тарга хүчний авалт эрс сайжирч байна.

БНМАУ—ын хөдөлмөрийн баатар Очирын туршлагаар зуны улиралд мал тарга хүч их авдаг өвс ус хужраар жигд сайн билчээрт сүрэг,суурийн малаа оторлон таргалуулж байгаа малчид цөөнгүй байна.

Гэвч хур бороо элбэг, чийг намаг ихтэй нөхцөлд малын тарга хүчний авалт аль ч нутагт сайн биш байгаа ба бас өнгөрсөн хаврын зуд малчин хүний ажил самбааг шалгасан юм гэж манай зарим малчид ярьж байгаа нь мал таргалуулах талаар бидний анхаарлыг татахгүй байж болохгүй. Энэ бүхнээс үндэслэж төрөл бүрийн малд тарга хүч авахуулахад сангийн аж ахуй, нэгдлийн удирдлага,бригад, хэсэг суурийн малчид бүр онц анхааралтай хандах хэрэгтэй.

Мал бүрийг хүч тарга авахуулахын тулд зориуд санаачлага гаргаж ажиллах нь шаардагдаж байна.

Мал хир зэрэг тарга хүч авах нь малчдын мал ажиллагааны аргаас шууд шалтгаална.

Сайн малчны мал тарга хүч сайн авсан байхад, залхуу муу малчны мал олигтой тарга тэвээрэг авч чадалгүй өнгөрдөг ба малын дотроос ажлын тэмээ, морьд үнээ ялангуяа төл мал тарга хүч муу авдаг урьдах жилүүдийн туршлагыг анхаарахгүй байж болохгүй.

Ийм учраас сангийн аж ахуй нэгдлийн нам,улс, олон нийтийн байгууллагууд сууриудын малд тарга хүч авалтын үзлэг хийх ба сууриудын тэмдэгт малыг тогтмол хэмжиж байх нь чухлаа.

Тарга хүч авах ид хугацаа болох 8, 9 дүгээр саруудад малыг хамгийн соргог, олон төрлийн өвс ургамалтай нуга тал хээрийн билчээр дагуулан хариулан ус хужрийг нарийн тохируулж хариулах хэрэгтэй.

Намрын улирал малын таргыг гүйцээх ба нэгэнт авсан хүчийг тогтоох маш хариуцлагатай үе мөн. Энэ үед малын суурь бүрт билчээрийг зөв сонгон олж малыг хариулагагүй залж сөл хөөлгөж хайлуулах гэмийг хааж зогсоох хэрэгтэй.

Суурийн мал дотроос хүч тэвээрэг авч чадаагүйг нь ялгаж хариулах буюу тугал унагыг саамаас чөлөөлж эхий нь хамт оторлох, хүч тарга онц муу малыг хивэг, өвс зэргийн нэмэгдэл тэжээлээр зориуд тэжээх арга хэмжээ авах хэрэгтэй.

Хүч тэвээрэг муу малыг бригадын хэмжээгээр 1—2 цэгт цугларуулан тэжээж онд оруулахаар одооноос зохих бэлтгэлийг хийх талаар бригадын дарга,эмч, зоотехникч нар онцгой анхаарал тавих хэрэгтэй.

Намрын улирал нь тарга хүч авахуулахын гадна 10 дугаар сараас эхлэн малын хүч тогтоох ажилд тун сүрхий зохион байгуулалттай, хяналт судалгаатай ажиллахыг шаарддаг.

Энэ үед малыг тогтмол хариулагад заавал шилжүүлсэн байх ба сойлго авахуулахын тулд ямарч малыг хашаагүй задгай маллах аргыг суурь бүрт нэвтрүүлэх хэрэгтэй. Малчид өвөлжөөнд аль болохоор орой буух нь чухал.

Өвөлжөөнд буусны дараа ч малыг хашихгүй аяндаа хашаа нөмөр газар мал өөрөө хоргодож ирэх үеийг хүлээх ёстой. Малыг байнга тогтуун хариулагатай болгох нь намрын хүч тогтоох гол арга байдаг учир малыг ширүүн туух усаар дугаах,дулаан хашаанд хаших, сөл хөөлгөж хөлөргөх явдлыг гаргахгүй байлгах талаар сангийн аж ахуй, нэгдлийн удирдлага, мал аж ахуйн мэргэжилтэн нар онцгой анхаарч суурь,малчин нэг бүртэй уйгагүй ажиллах хэрэгтэй.



## Өндөр ургац даллаж байна

### Хадсан өвс шимтэй, хадуурын ир гантай

Өнжүүл сумын хөдөлмөрчид малын тэжээл бэлтгэхийн ач холбогдлыг дүүрэн үнэлж малын тэжээл бэлтгэх ажилд гялалзсан сайхан амжилт гаргаж байна.

Өнжүүл сумын «Ялалт» нэгдлийнхэн энэ жил 3200 тонн өвс хадахаас 3501 тонн өвс хадаж төлөвлөгөөгөө 106 хувиар биелүүлэв. Тус сумын Өлзийбэлиг ахлагчтай нэгдүгээр бригад 1020 тонн өвс хадаж төлөвлөгөөгөө 112 хувиар биелүүлж сумандаа түрүүлэв.

3 дугаар бригадын хадланчин Балган өдөрт морин хадуураар 6,5 га талбай хадаж га-гаас 7,1 центнер ургац авч бусдаасаа түрүүлэв.

Тус сумын хөдөлмөрчид ногоон өвс бэлтгэхийн хамт шингэн сүү таанатай хольсон сорс 380 кг, тарваганы сайн хөдоод 500 ширхэг, агь хүмүүл 3 тонныг малын тэжээлд нөөцлөн бэлтгээд байна.

«Ялалт» нэгдлийн хамт олон мал аж ахуйн өвлийн бэлтгэлийг хангах 45 хоногийн ажлын төлөвлөгөө зохиож суурь малчдын өвөлжих нутаг усыг зааж, өвөлжөө бүрт 40 тонн өвс хадхаар шуурхайлан ажиллаж байна.

*Манай сурвалжлагч*

### Тээвэрчдийн туслалцаа

Аймгийн 13 дугаар авто баазын хэсэг тээвэрчид Сэргэлэн сумын «Авдархангай» нэгдлийн үхрийн фермүүдийн өвөлжөө хаваржаанд 303 тонн өвс татав.

Энэ ажилд жолооч Цэдэндамба, Бадарч, Содномпил, Чулуунбаатар, Дорлиг, Бэтцэнгэл, Жадамбаа, Дашбал, Лувсанжав,Нямдорж, Жамбал нар 3—4 ресс хийж 16—20 тонн өвс татаж бусдаасаа илүү амжилттай ажиллав.

*Д. Бадарч*

### Н а м а р

Буурал хярууны гялганах өнгөөр  
Буцах шувуудын ганганах дуунаар  
Алтан чимгээ модод зүүсээр  
Арвин ургацаа тал найгуулсаар  
Хонгор намар айлчилж ирлээ  
Хосгүй бүтээл ундарч гарлаа.

Талын тэртээх хадланчдын нуруу  
Тариан дундах комбайн дуунаар  
Өнөр олны өрнүүн хөдөлмөр  
Өнтэй өвөлжихийн өөгхөн бэлгээр  
Хонгор намар айлчилж ирлээ  
Хосгүй бүтээл ундарч гарлаа.

*Ш.Цэрэндоо*

### Арвин ургац авч байна

Алтанбулаг сумын «Монгол-Солонгосын найрамдал» нэгдлийнхэн төмс хүнсний ногоо хураах ажилд шуурхайлан орж арвин ургац авч байна.

9 дүгээр сарын 14-ний байдлаар 20 га-гийн төмс хураахаас гурав хоногт 11 га-гийн төмс хурааж нэг га-гаас 10—11 тонн ургац авч төмс ялгах ажлыг хослуулан хийж ирэх жилийн тарих үрээ бэлтгэж байна.

Тус сумын дунд сургуулийн пионер сурагчид амралтын цагаар нэгдлийн төмс, хүнсний ногоо хураах ажилд биечлэн тусалж төмс хураалтыг хоёр хоногт дуусгах зорилт тавиад чармайн ажиллаж байна.

Баянбараат сумын «Баянамьдрал» нэгдлийн тариалангийн талбайд Улаанбаатар хотын техник туслалцааны баазын 74 хүн хоёр бригад болон ажиллаж 2 хоногт 7 га-гийн төмс хурааж га-гаас 8—9 тонн ургац авч шефийн халуун туслалцаа үзүүлэв.

*Д.Дондогдорж*



**ЗУРАГ ДЭЭР:** Дэлгэрхаан сумын „Залуучуудын хөгжил“ нэгдлийн хоньчин Чүлтэмсүрэнгийн суурийнхан хонио ахарлаж байна

